

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2017 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2017 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА**

3 дугаар зүйл.Нийгмийн даатгалын санд 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчдын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Орлогын төрөл	Дүн /сая төгрөгөөр/
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	1,467,962.8
	1.1.Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	546,617.8
	1.2.Ажиллагсдаас төлөх шимтгэл	525,603.0
	1.3.Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл	160,717.1
	1.4.Нөхөн олговор авагчийн нийгмийн даатгалын шимтгэл	0.3
	1.5.Цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл	52.0
	1.6.Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хариуцах иргэдийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл	58,680.5
	1.7.Сайн дурын даатгуулагчаас төлөх шимтгэл	59,352.7
	1.8.Эрүүл мэндийн даатгалын бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	27,326.8
	1.9.Гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийн төлөх шимтгэл	3,078.2